



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 1122

Улаанбаатар хот

Тамга, тэмдэг түших, хэвлэмэл хуудас
хариуцсан ажилтан томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг, 2024 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.5.8 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын тамга, тэмдэг түшигчээр Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Д.Ганболдыг томилсугай.

2. Тамга тэмдгийг холбогдох зааврын дагуу хадгалж хамгаалахыг Архив, бичиг хэргийн ажилтан Д.Долгоржавт даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 1/23

Улаанбаатар хот

“Улаанбаатар травэл экспо-2025” аялал
жуулчлалын үзэсгэлэн арга хэмжээг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/624 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дах заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэд жуулчдад аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээ, мэдээллийг хүргэх, салбарын хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор “Улаанбаатар травэл экспо-2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг 2025 оны 05 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Улаанбаатар зочид буудлын Их танхимд зохион байгуулсугай.

2.Үзэсгэлэнг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж, шаардагдах 27,000,000 (хорин долоон сая) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3.Арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар A/24

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны A/155 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүүхдийн баяр"-ыг тохиолдуулан газрын албан хаагчдын хүүхдүүдийн дунд арга хэмжээ зохион байгуулахыг Эцэг эхийн зөвлөл (С.Туул)-д даалгасугай.

2. Арга хэмжээнд шаардагдах 2,350,000 (хоёр сая гурван зуун тавин мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА

D. Batsukh

Д.БАТСҮХ



مکتبہ اسلامیہ

مکمل



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн
ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтэд
мэдээлэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/546 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотын иргэдийг эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийг бүрэн хангасан иргэн төвтэй, байгаль орчинд ээлтэй, технологид суурилсан, олон улсад өрсөлдөх чадвартай хот болгох зорилгоор Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2025 оны 04 дүгээр сарын 29,30-ны өдрүүдэд олон нийтэд мэдээлэх ажлыг Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

2.Арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж шаардагдах санхүүжилтийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3.Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАГСҮХ



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

“Монгол хүүхдүүд-Шидэт хотын хүүхдүүд”
нэгдсэн арга хэмжээний баярын парадыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/727 дугаар захирамж, 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Монгол хүүхдүүд-Шидэт хотын хүүхдүүд” нэгдсэн арга хэмжээний баярын парадыг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан маршрутын дагуу зохион байгуулсугай.

2.Арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж шаардагдах санхүүжилтийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3.Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс (Н.Алтанзаяа)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ



• • • • •

• • • • •
- (• • • • •) • • • • •
• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •

• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •
• • • • •

• • • • •
• • • • •
• • • • •

• • • • •
• • • • •
• • • • •

• • • • •